

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

БНХАУ-ЫН ТЕЛЕВИЗИЙН ХӨГЖЛИЙН
ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛД

Г.Мэндхүү*, Г.Лхагвадорж **

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

** МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: БНХАУ, Хятадын төв телевиз, макро стратеги, өргөн нэвтрүүлгийн эрх зүйн зохицуулалт, зар сурталчилгаа

Хүн амынхаа тоогоор дэлхийд нэгдүгээрт бичигддэг БНХАУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нэн ялангуяа телевизийн салбар нь нэлээн эрчимтэй хөгжжээ. Өнөөдөр Хятадын телевиз эфир дамжуулах уламжлалт аргаас гадна мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг хослуулан үр ашигтай ажиллаж байна. Мэдээлэл авах гол эх сурвалж нь телевиз болсон гэдгийг тус улсын жирийн иргэд ч хүлээн зөвшөөрдөг.

Хятадын нийслэл Бээжин хотод 1958 оны хавар телевизийн студи барьж ашиглалтад оруулжээ. Тус улсад телевизийн нэвтрүүлэг дамжуулах анхны туршилтыг 1958 оны 5-р сарын 1-нд хийжээ. Үүнээс дөрвөн сарын дараа буюу 1958 оны 9-р сарын 2-нд Бээжингийн телевиз тогтмол нэвтрүүлэг

дамжуулж эхэлсэн байна. 1958-аас 1960 оныг хүртэл долоо хоногт дөрвөн удаа нэвтрүүлэг дамжуулж байв. 1960 оноос Бээжингийн телевиз өдөр бүр нэвтрүүлэг үзүүлдэг болж үйл ажиллагаа нь жигдэрчээ. Тухайн үед БНХАУ-ын нийслэл Бээжин хотоос гадна хүн ам төвлөрсөн, худалдаа арилжаа, үйлдвэрлэл хөгжсөн томоохон хотуудад телевизийн студи байгуулж байв. Тухайлбал, 1958 оны 10-р сарын 1-нд Шанхай хотод, мөн оны 12-р сарын 20-нд Харбин хотод телевизийн төв нээгджээ. Тухайн үед ЗХУ-д үйлдвэрлэсэн хар цагаан зурагт БНХАУ-д худалдаалагдаж байв.

Өдгөө судлаачид Хятадын телевизийн түүхийн асуудалд анхаарлаа хандуулж, хөгжлийн үе шатаар нь ангилах оролдлого хийж эхэлжээ. Тухайлбал Хятадын сэтгүүл зүйн түүх судлаач Ян Ли улсынхаа телевизийн хөгжлийн үе шатыг тав хуваажээ. Үүнд:

- 1958-1966 он. БНХАУ-д телевиз байгуулж эхэлсэн үе.

- 1967-1976 он. Соёлын хувьсгалын үеийн Хятадын телевиз

- 1977-1982 он. Хятадад телевиз идэвхтэй хөгжсөн үе

- 1983-1989 он. Хятадад телевиз цэцэглэн хөгжсөн үе

- 1990 оноос хойш тоон технологийн эрин үе¹.

Хятадын телевизийн хөгжлийн эдгээр үе шатыг тоймлон тайлбарлая.

1958-1966 он. БНХАУ-д телевиз байгуулж эхэлсэн үе. БНХАУ-д телевиз байгуулагдсан мөчөөс эхлэн уран бүтээлчид нь өөрийн орны үзэгчдийн оюуны эрэлт хэрэгцээг хангахаас гадна гадаадын үзэгчдэд зориулан нэвтрүүлэг бэлтгэхэд онцгой анхаарал хандуулж байлаа. Тухайлбал, 1963 онд БНХАУ-ын Бээжин, Шанхай, Харбин, Гуанжоу хотын телевизийн удирдлагууд гадаад суртал ухуулгын асуудлаар хуралдсан байна. Хятад орны тухай түүх, соёл, урлаг, зан заншил, хүн ардын аж амьдралын өнөөгийн бодит байдлыг тусгасан дэлгэцийн бүтээл туурвиж гадаадын үзэгчдэд түгээх асуудлыг уг хурлаар хэлэлцэж байлаа. Дашрамд дурдахад 1960 онд БНХАУ-ын телевизүүд бэлтгэсэн нэвтрүүлгээ гадаадын долоон улс руу илгээж байсан бол 1965 онд нэвтрүүлэг харилцан солилцох гэрээг дэлхийн 27 улстай байгуулжээ.

1967-1976 он. Соёлын хувьсгалын үеийн Хятадын телевиз. 1967 оны 1-р сарын 1-нд Бээжингийн телевизийн үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг нам засгаас гаргажээ. Үүний дараа бусад хотын телевизүүдийг ч хаасан байна. Ингэснээр БНХАУ-д телевизийн салбар зогсонги байдалд оров. 1968 оны сүүлээр орон нутгийн телевизүүд

нэвтрүүлгээ сэргээжээ. Дашрамд дурдахад 1975 онд БНХАУ-д 463 мянган зурагт байв. Үүний 4000 нь Хятадад үйлдвэрлэсэн өнгөт зурагт байлаа. 1,9 мянган ширхэг импортын зурагт ашиглагдаж байсан гэдэг статистик баримт мэдээ бий. 1976 онд Соёлын хувьсгал дуусмагц Хятадын телевизийн салбар эргэлт буцалтгүй сэргэн мандлын үедээ оржээ.

1977-1982 он. Хятадад телевиз идэвхтэй хөгжсөн үе. 1979 оны 5-р сарын 1-нд Бээжингийн телевизийг “Хятадын төв телевиз” (China Central Television) гэж нэрлэх шийдвэр гарав. Ийнхүү Хятад орны хамгийн нөлөө бүхий, нэр хүндтэй телевиз нь CCTV юм хэмээн хүлээн зөвшөөрөгдөх үндэс суурь бүрджээ. 1979 оны 8-р сард Хятадын радио өргөн нэвтрүүлгийн асуудал эрхлэх төв газарт телевизийн хөтөлбөрийн асуудлаар хурал зохион байгуулжээ.

Энэ хурлын шийдвэрийн дагуу 1979 оны 10-р сард теле нэвтрүүлгийн үзэсгэлэнг зохион байгуулжээ. Энэ үзэсгэлэнд БНХАУ-ын 25 телевиз нийтдээ 100 гаруй цагийн нэвтрүүлэг илгээсэн байна. Агуулга, хэлбэр нь сонирхолтой нэвтрүүлгийг бусад хотын телевизээр үзүүлэх, Хятадын телевизүүд дотооддоо харилцан нэвтрүүлэг солилцох тохиролцоонд хүрч байв. БНХАУ-д хувь хүн, иргэн нь хувийн бизнес эрхлэх, аж ахуйн нэгж байгуулж үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхийг төр нь зөвшөөрдөг. 1979 оны 1-р сарын 28-нд БНХАУ-ын Шанхай хотын телевизээр арилжааны зар сурталчилгаа үзүүлжээ. Тухайн өдрийн турш найман удаагийн давтамжтайгаар

арилжааны зар сурталчилгаа нэвтрүүлсэн юм.

1983-1989 он. Хятадад телевиз цэцэглэн хөгжсөн үе. 1983 оны 3-р сарын сүүлээр Бүх Хятадын телевиз, радио өргөн нэвтрүүлгийн байгууллагуудын 11 дэх удаагийн хурал болжээ. Энэ хурлаас хойш богино хугацаанд шинээр телестанцууд нээгдэв. 1982 онд БНХАУ-д орон нутгийн түвшинд хорь гаруй телевиз ажиллаж байсан бол 1985 онд орон нутгийн телевизийн тоо 172 болж нэмэгджээ. 1984 оны 4-р сарын 8-нд Хятад дэлхийн тойрог замд анхны хиймэл дагуулаа гаргажээ. Мөн ондоо багтаан Бээжин, Өрөмч болон бусад алслагдмал хотуудад сансрын хиймэл дагуулаас телевизийн дуу дүрс хүлээн авах станц байгуулжээ. 1986 оны байдлаар БНХАУ-д сансраас телевизийн нэвтрүүлэг хүлээн авах станц 2000 байгуулжээ. 1990 оны босгон дээр Хятадын газар нутгийн 78 хувь нь сансрын хиймэл дагуулаас телевизийн нэвтрүүлэг хүлээн авч байлаа. 1988 оноос өмнө БНХАУ-ын телевизийн уран бүтээлчид өнгөт хальсан дээр нэвтрүүлэг, телевизийн богино хэмжээний кино, жүжиг туурвиж байв. Харин 1988 оны 3-р сарын 15-ны өдрөөс эхлэн Хятадын Төв Телевиз (CCTV) өнгөт нэвтрүүлэг тогтмол явуулдаг болжээ. Энэ бол Хятадын телевизийн түүхэнд шинэ хуудас нээсэн хэрэг байлаа. 1987 оны 7-р сард БНХАУ-д 600 сая хүн телевизийн нэвтрүүлэг хүлээн авч үзэх боломж нөхцөлөөр хангагдсан байлаа. Энэ нь тухайн үеийн Хятадын хүн амын 56 хувь нь гэсэн үг. 1987 онд БНХАУ-д 120 сая ширхэг зурагт ашиглагдаж байв. Статистикийн энэ тоо баримтаас

үзэхэд телевиз Хятадын хүн амын мэдээлэл авах гол эх сурвалж нь болж чаджээ.

1990 оноос хойш тоон технологийн эрин үе. Сүүлийн хорин зургаан жилд БНХАУ-ын телевизийн өнгө төрх, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж байгаа арга барил нь ч үндсээрээ өөрчлөгдсөн байна. Телевизийн сувгууд төрөлжиж, шууд нэвтрүүлэг, үзэгчдийн чөлөөт цагт зориулсан уралдаант цэнгээнт нэвтрүүлгийг чанарын шинэ түвшинд хийдэг болжээ. 1994 онд БНХАУ-д 766 телевиз ажиллаж байв.

Мөн телевизийн нэвтрүүлгийг сансрын хиймэл дагуулах хүлээн авах, дахин дамжуулах дэд станц 38917 хүрчээ. Одоо БНХАУ-д 448 сая ширхэг зурагт ашиглагдаж байна гэсэн дүн мэдээ бий. Зурагт ашиглагдаж байгаа тоогоороо дэлхийд нэгдүгээр байранд зүй ёсоор оржээ. 1990 онд БНХАУ-ын нийт хүн амын 75 хувь нь телевизор үзэх боломжтой болжээ². Харин 1994 оны сүүл, 1995 оны эхээр Хятадын хүн амын 83,4 хувь нь телевизийн нэвтрүүлэг үзэх нөхцөл боломжоор хангагдсан байсан бол 2003 онд энэ үзүүлэлт 94,62 хувь болсон юм. 2016 оны байдлаар 97 хувьтай байна.

БНХАУ-д бүх телевиз нь төр засгийн байгууллагын мэдэлд байдаг боловч арилжааны зар сурталчилгааг дамжуулдаг. БНХАУ-д 1979 оноос телевизээр зар сурталчилгаа дамжуулж эхэлжээ. Одоо тус улсын телевизүүд зар сурталчилгаанаас санхүүжилтийн үлэмж хэсгээ бүрдүүлдэг. Тус улсын телевизээр үзүүлж байгаа зар сурталчилгааны агуулга, зохиомж,

хэлбэр хийцийг ажиглахад үндэсний уламжлал, ёс заншил, соёлд тулгуурлан орчин үеийн бүтээгдэхүүний давуу талыг нь харуулахаар чармайж байгааг нь мэдрэгдэг. БНХАУ-ын телевизээр дамжуулж буй бүтээгдэхүүний жагсаалт гаргавал, нэн тэргүүнд гоо сайхны бүтээгдэхүүн, хувцас, эм тан, гар утас компьютер зэрэг цахилгаан барааг нэрлэж болно. Хятадын телевизээр 15 секундийн зар сурталчилгаа дамжуулах төлбөр нь (Хятадын төв телевизээр үдшийн оргил цагаар) ойролцоогоор 6000 юань байдаг.

БНХАУ-ын нэр хүндтэй, нөлөө бүхий телевиз нь Хятадын төв телевиз (CCTV) юм. Энэ телевизийн үүсэл, хөгжил, уран бүтээлийн талаар дагнан бичсэн ном зохиол бишгүй олон хэвлэгдэн гарсны нэг нь Хятадын судлаач Янь Вэйгуны “CCTV-ийн хөгжлийн түүх” хэмээх бүтээл юм. Номын зохиогч Янь Вэйгун “Телевизийн салбарын макростратегийн өнцгөөс авч үзвэл, CCTV-ийн хөгжлийг гурав хувааж болно”³ гэж цохон тэмдэглэжээ. Түүний санал болгосон үечлэлээр 1978-1993 оны хооронд CCTV-ийн уран бүтээлчид сэтгүүл зүйн янз бүрийн төрөл зүйлээр нэвтрүүлэг бэлтгэж, урын сангаа шинэ нэвтрүүлгээр баяжуулж байсан. Тухайлбал, 1978 оноос “Цаг үеийн мэдээ” (Синвэн ляньюбо) нэвтрүүлгийг сэргээжээ. 80-аад оноос Хятадын телевизийн уран бүтээлчид нэгдсэн бодлогоор баримтат кинонд анхаарлаа хандуулсан байна. 1983 оноос CCTV “Хаврын баярт зориулсан үдэш” (Чшунде ляньюань уаньхуй) тусгай баярын нэвтрүүлэг бэлтгэдэг болсон байна. Жил бүр Хятадын цагаан сарын баярын шинийн

нэгэнд энэ нэвтрүүлгийг үзүүлдэг бөгөөд хамгийн олон үзэгчтэй нэвтрүүлгийн тоонд зүй ёсоор багтдаг. Мөн 1980-аад оны хоёрдугаар хагасаас Хятадын телевиз спортын нэвтрүүлгийн ур чадварыг сайжруулах, олон ангит кино бүтээж эхэлжээ.

CCTV-ийн хөгжлийн хоёрдугаар үе нь 1993-2000 оныг хамардаг. 90-ээд оны дундуур тус телевиз төрөлжсөн сувгууд нээж эхэлжээ. Бүх нийтэд зориулсан, эдийн засгийн, цэнгээнт нэвтрүүлгийн, спортын, хилийн чанадахь үзэгчдэд зориулсан суваг, хүүхдийн нэвтрүүлгийн суваг, уран сайхны киноны суваг, олон ангит киноны суваг нээжээ. Үүний зэрэгцээ нэвтрүүлгийн төрөл зүйлд өөрчлөлт гарч, уран бүтээлчдийн ур чадвар ч дээшилсэн байна. 1990-ээд оны сүүлээр CCTV хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргасан нь санхүүгийн байдлыг нь сайжруулахад гол дэмжлэг болжээ.

CCTV-ийн хөгжлийн макро стратегийн гуравдугаар үе нь 2000 оноос хойшх хугацааг хамардаг. Энэ үед тус телевиз дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх талаар анхаарч ажилласан байна. Хятадын төв телевиз гадаадын үзэгчдэд зориулсан нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн үзүүлдэг сувгийн тоог эрс нэмэгдүүлжээ.

Одоо тус телевиз гадаадын үзэгчдэд Хятад орны түүх, байгаль, ёс заншлыг таниулан сурталчлах, дэлхий дахинд болж байгаа үйл явдлын талаар Хятадын өнцгөөс тайлбарласан мэдээлэл түгээх зорилгоор англи, орос, испани, франц, араб хэлээр 24 цагийн турш нэвтрүүлэг үзүүлдэг. Мөн Хятадын дотоодын

үзэгчдэд зориулан тусгай төлбөртэй сувгууд ч хэд хэдийг нээжээ. CCTV нь орчин үеийн шилдэг техник технологи ашигладаг бөгөөд хиймэл дагуулын хөдөлгөөнт систем хэрэглэж Хятадын нутаг дэвсгэр болон дэлхийн дахинд болж байгаа чухал үйл явдлыг шууд дамжуулан үзүүлэх боломжтой. Тус телевиз Хятадын бүх хотод мөн хилийн чанадад 14 хотод CCTV байнга сурвалжлагч ажиллуулдаг.

Өмнөд хөрш БНХАУ-д телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн эрх зүйн зохицуулалтын та-

лаар энд дурдах нь зүйтэй юм. Одоогоор БНХАУ-д ОНМХ-ийн тухай нэгдсэн хууль батлагдаагүй. Телевиз, радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээгээр хангах тухай хууль, Телевиз, радиостанцын лицензийн тухай хууль, Теле, радио өргөн нэвтрүүлгийн тухай

хууль зэрэг эрх зүйн баримт бичгээр энэ салбарын үйл ажиллагааг зохицуулдаг. Эдгээр хуулиудын зарим чухал хэсгээс нь онцлон авч үзье. Хиймэл дагуул ашиглан телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг дамжуулахтай холбоотой зохицуулалтыг сайжруулах зорилгоор 1993 оны 10-р сарын 5-нд БНХАУ-ын Төрийн Зөвлөл 128 дугаар тогтоол баталжээ. Энэ тогтоолоор хиймэл дагуулаар телевиз, радиогийн нэвтрүүлэг дамжуулахад хэрэглэх тоног төхөөрөмж үйлдвэрлэх, худалдах, суурилуулах стандарт бий болгожээ⁴.

Хятадын радио телевизийн салбарт хэрэглэж байгаа өөр нэг тогтоол бол 1994 оны 2-р сарын 3-нд Телевиз, радиогийн яамны баталсан “Кабелийн телевизийн тухай” эрх зүйн баримт бичиг юм. Энэ баримт бичгийн дагуу БНХАУ-д кабелийн телевизийн үйл ажиллагааг зохицуулдаг байна. Кабелийн телевиз нь улс, муж, хот суурингийн телевизийн нэвтрүүлгийг дахин дамжуулахдаа зохиогчийн эрхийн зөвшөөрөл, лиценз авах ёстой гэж тусгажээ.

«

Одоогоор БНХАУ-д ОНМХ-ийн тухай нэгдсэн хууль батлагдаагүй. Телевиз, радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээгээр хангах тухай хууль, Телевиз, радиостанцын лицензийн тухай хууль, Теле, радио өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгээр энэ салбарын үйл ажиллагааг зохицуулдаг

»

БНХАУ-ын Телевиз, радиогийн яам 1995 оны 9-р сарын 1-нд “Хилийн чанад дахь телевизийн бүтээл бүтээгч нартай хамтран ажиллах тухай” шийдвэр гаргажээ. Мөн тус яам 1995 оны 10-р сарын 18-нд “Телевизийн олон ангит киноны лицензийн тухай” эрх зүйн баримт бичиг батлав.

Ингэснээр БНХАУ-д шинээр бүтээх, телевизээр үзүүлэх олон ангит кинотой холбоотой бүх харилцааг энэхүү яам хариуцах болжээ. Ингэснээр Хятадын олон ангит кинонд тавигдах техникийн шаардлага нэгдсэн хэм хэмжээнд хүрч, бүтээлийн агуулга, уран бүтээлчдийн ур чадвар эрс сайжирсан юм. 1996 оны 5-р сарын 24-нд Телевиз, радиогийн яамны “Телевиз, радио станц байгуулах зөвшөөрөлд хяналт тавих тухай” тогтоол гаргав. Энэ тогтоолын дагуу мужийн захиргааны газар телевиз, радиостанц шинээр нээх эсэх

асуудлыг хянан шийдвэрлэж байх болжээ. Төв засгийн газар, муж, хот, суурингийн засаг захиргаа л телевиз, радио станц байгуулах эрхтэй бөгөөд бусад аж ахуйн нэгж, хувь хүнд ийм боломж байхгүй.

1997 оны 8-р сарын 11-нд БНХАУ-ын Төрийн Зөвлөл “Телевиз, радио өргөн нэвтрүүлгийн тухай” 228 тоот тогтоол гаргаж, салбарын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлсон байна. Хятадын сэтгүүл зүйг зохицуулах эрх зүйн чухал баримт бичиг болсон энэ тогтоолд телевиз, радио өргөн нэвтрүүлгийн салбарын удирдлага зохион байгуулалтын зарчмыг тусгасан байна. Нэвтрүүлэг бэлтгэх, түүнийг түгээн дэлгэрүүлэх, шинээр телевизийн төв байгуулахад шаардлагатай нөхцөл зэргийг нарийвчлан тусгажээ. Мөн энэ тогтоолд телевиз, радио станцын үйл ажиллагааны журам, лиценз олгох дэг журмыг оруулжээ.

2001 оны 12-р сарын 25-нд БНХАУ-ын Төрийн Зөвлөл “Киноны тухай” тогтоол баталжээ. 2002 оны 2-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн энэ тогтоолд БНХАУ-д кино бүтээх, гадаадын орнуудад Хятадын киног нийлүүлэх, бусад улс орноос кино худалдан авч олон түмэнд үзүүлэхтэй холбоотой асуудлыг нарийвчлан тусгажээ.

Ийнхүү БНХАУ-ын төр засгийн баталж хүчин төгөлдөр сахин мөрдөж байгаа телевиз, радиогийн салбарын үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн баримт бичгүүд нь нийгмийн шаардлага, бодит нөхцөл байдалд тулгуурласан тул амьдралд нийцсэн байдаг.

БНХАУ-ын телевиз нь улс төр-үзэл суртлын үүднээс болон нийгмийн үүргээрээ бусад улс орны телевизийн тогтолцооноос эрс ялгардаг. Төр, засгийн газрын удирдлага доор телевизийн өргөн нэвтрүүлгийн салбарт өөрийн гэсэн удирдлага зохион байгуулалтын тогтолцоо, эдийн засгийн бүтэц бүрэлджээ. Удирдлага зохион байгуулалтын хувьд нэгдүгээр түвшинд БНХАУ-ын Коммунист намын Төв Хорооны, хоёрдугаар түвшинд муж, гуравдугаар түвшинд хотын, дөрөвдүгээр түвшинд хөдөө орон нутгийн гэж хуваасан байна. Ингэснээр БНХАУ-ын телевизүүдийн статус тодорхой болж нийтлэл нэвтрүүлгийн бодлогоо тодорхойлоход нь гол суурь болж өгдөг. БНХАУ-ын Телевиз, радиогийн яам, орон нутгийн засаг захиргааны газар телевиз радиотой холбоотой асуудлыг хариуцан ажилладаг. БНХАУ-д бүх телевиз нь төрийн өмч бөгөөд телевизийн зорилго нь төрийн бодлогыг сурталчлах, үзэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангах, үзэгчдийг зугаацуулах юм.

БНХАУ-ын санхүү эдийн засгийн үсрэнгүй хөгжлийг дагаад телевизийн салбарын санхүүжилт ч хувьсан өөрчлөгдөж эхэлсэн байна. Тухайлбал, кабелийн болон хиймэл дагуулын телевизийн тоо нэмэгдэж байгаатай уялдуулан Шанхайн болон бусад хотын телевизүүдийн санаачилгаар телевиз дотор бүтцийн өөрчлөлт хийгдэж зар сурталчилгааны алба хэлтэс нээгджээ. Ингэснээр Хятадын телевиз нь ямар нэгэн аж ахуйн нэгжийг зах зээлтэй холбох гүүр, туслагч нь болсон юм. Аж ахуйн нэгжүүд телевизээр зар сурталчилгаа төлбөртэй дамжуулснаар

телевизийн салбарын цаашдын хөгжилд хувь нэмэр оруулж байна. Ямар нэгэн нэвтрүүлгийн дундуур үзүүлсэн зар сурталчилгааны орлогыг тухайн нэвтрүүлгийг боловсронгуй болгоход л зориулж байх “нэвтрүүлэгт чиглэгдсэн санхүүжилт” гэдэг тогтолцоог 1987 оноос хойш хэрэгжүүлж өнөөг хүрчээ. Одоо БНХАУ-ын телевизүүд нь улсын төсвөөс, мөн арилжааны зар сурталчилгааны орлогоос, дотоод нөөц бололцоогоо ашиглаж олсон орлогоос гэсэн гурван эх үүсвэрээс санхүүжиж байна. Хэдийгээр тус улсад бүх телевиз төрийн мэдэлд байдаг боловч үзэгчдийн сонирхол татахуйц, эдийн засгийн хувь үр ашигтай байх нэвтрүүлэг бэлтгэхийн төлөө янз бүрийн муж, хотын телевизийн сувгуудын дунд ширүүн өрсөлдөөн өрнөдөг байна. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын телевизүүд дотооддоо харилцан нэвтрүүлэг солилцох, хамтарсан нэвтрүүлэг бэлтгэх хэлбэрээр ажиллаж тодорхой амжилтад хүрчээ.

Мөн аливаа телевизийн нэвтрүүлгийн ерөнхий санаа, зорилго зарчим, нэвтрүүлэг хийх аргачлалыг нь санаачлагч байгууллагаас нь тодорхой төлбөр төлж авах, улмаар өөрийн эрх орондоо хийдэг туршлага дэлхийн телевизийн салбарт хэдийнэ нэвтэрчээ. Энэ аргыг эдийн засаг санхүүгийн салбарт франчайзинг (англ. franchise, «лиценз», «зөвшөөрөл») гэж нэрлэдэг. Үйл ажиллагаа явуулахад бодож боловсруулсан загварыг санаачлагч нь өөр этгээдэд худалдаж байгааг франчайзинг гэж хэмээн эдийн засгийн шинжлэх ухаанд тодорхойлжээ⁵.

Энэ жишгээр гадаадын бусад улс орнуудад хийгддэг уралдаант цэнгээнт нэвтрүүлгийг дотооддоо хийх эрх, албан ёсны зөвшөөрлийг Хятадын телевизүүд худалдан авч байна. Тухайлбал, “Саятан болохыг хүсвэл”, “Авьяаслаг хятадууд”, “Шоо”, “Аав аа, бид хаашаа явж байгаа вэ?” гэх мэт уралдаант цэнгээнт нэвтрүүлгийг албан ёсны зөвшөөрөлтэйгөөр хийжээ. Ингэснээр Хятадын телевизийн уралдаант цэнгээнт нэвтрүүлэг, реалити-шоу хөгжлийнхөө шинэ шатанд гарсан юм.

БНХАУ-ын телевизийн салбарын түүхэн замнал, өнөөгийн байдалд ажиглалт хийж үзээд, дараах ерөнхий дүгнэлтийг хийж байна. БНХАУ-ын хэвлэл мэдээллийн салбар бүхэлдээ тус улсын нам төрийн шууд удирдлагаар амжилттай хөгжиж байна. Сэтгүүл зүй судлаачид БНХАУ-ын телевизийн салбарын хөгжлийг тав ангилж үечилж хуваахдаа тус улсын түүхэн замнал, нийгмийн өнгө аяс, технологийн хөгжлийн түвшинтэй нь уялдуулан авч үзсэн. Хятадад телевизүүд нь төрийн мэдэлд харьяалагддаг боловч арилжааны арилжааны шинж тэмдэг улам бүр нэмэгдэж байна. Бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний тухай зар сурталчилгааны хувь хэмжээ нэмэгдэж, үндэстэн дамнасан томоохон корпорацын сурталчилгааг БНХАУ-ын телевизээр үзүүлж байгаа нь содон үзэгдэл гэж тооцогдохоо больжээ. Техник, технологийн шинэчлэл хийж Хятадын телевиз гадаадын үзэгчдэд зориулсан нэвтрүүлгийг хэд хэдэн сувгаар дэлхий дахинд сансрын хиймэл дагуулаар дамжуулж байна. Үүний зэрэгцээ

барууны орнуудын арилжааны телевизээр гардаг төрөл бүрийн уралдаант цэнгээнт нэвтрүүлгийг хийх албан ёсны зөвшөөрлийг авч Хятадад хийж байна.



өрөөр хэлбэл, даяаршил Хятадын телевизийн салбарт ч нөлөөгөө үзүүлж байгаагийн илрэл нь юм.

Ишлэл

¹ Ян Ли. Новейшая история китайского ТВ // «Медиаскоп» электронный научный журнал факультета журналистики МГУ имени Ломоносова. 2006.

№1.<http://www.mediascope.ru>

² Зулькафиль М., Чойсамба Ч. 2005. Сэтгүүл зүйн түүх. УБ., х. 350.

³ Янь Вэйгун. 1998. CCTV-ийн хөгжлийн түүх. Бээжин, х. 5-6.

⁴ Го Чэнчжи. 1991. Хятадын телевизийн түүх. Хятадын Ардын Их Сургууль, х. 67-68.

⁵ Котлер Ф. 2004. Маркетинг менеджмент. СПб., с. 575.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М., Чойсамба Ч. 2005. Сэтгүүл зүйн түүх. УБ.

2. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.

3. Наранжаргал Х. 2003. Телевизийн сэтгүүл зүй. УБ.

4. Го Чжэнчжи. 1991. Хятадын телевизийн түүх. Хятадын Ардын Их Сургууль.

5. Котлер Ф. 2004. Маркетинг менеджмент. СПб.

6. Янь Вэйгун. 1998. CCTV-ийн хөгжлийн түүх. Бээжин.

7. Ян Ли. Новейшая история китайского ТВ // «Медиаскоп» электронный научный журнал факультета журналистики МГУ имени Ломоносова. 2006. №1.

Резюме

В статье рассматривается становление и функционирование телевидения КНР. В частности, особое внимание уделяется периодизации телевидения Китая, и работе Центрального телевидения Китая (CCTV). Дается общая характеристика о правовом регулировании деятельности в этой сфере.